

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: САГ-2019/139/14-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
3.2	Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
3.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.5	Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, гүйцэтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
АЗЗА	Авто замын засвар арчлалт
ТӨКХ	Төрийн өмчит хувьцаат компани



ГОВЬ-АЛТАЙ АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ С.ДУГАРСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/530
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Говь-Алтай АЗЗА ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн захирал С.Дугарсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Говь-Алтай АЗЗА ТӨХК-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Говь-Алтай АЗЗА ТӨХК 2018 оны санхүүгийн тайланг тодруулгын хамт Эвиденсе Аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говь-Алтай АЗЗА ТӨХК талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл явц юм. Говь-Алтай аймгийн болон Монгол Улс, Олон улсын авто замын хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжин биелэгдэх бөгөөд, зам тээврийн хөдөлгөөний бэлэн байдлыг өндөр түвшинд хангах нэн тэргүүний шаардлагатай. Үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсноор хүрэх оргил эрхэм зорилго тодорхой болж цаашид үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэл тодорч түүнд хүрэх тэмүүлэл, удирдлага хамт олны эрхэмлэх зүйлийг багтааж байгаа болно.

Үйл ажиллагааны чиглэл:

Говь-Алтай АЗЗА ТӨХК нь 1968 онд СНЗ-ийн 342 дугаар тогтоолоор Говь-Алтай аймгийн “Зам ашиглалтын анги” нэртэйгээр байгуулагдаж 1993 онд Төрийн өмчит УҮГ, 1999 оноос Говь-Алтай АЗЗА ХХК, 2005 оноос Говь-Алтай АЗЗА ТӨХК болон зохион байгуулагдсан. “Улсын чанартай авто зам, замын байгууламжийн хөдөлгөөний бэлэн байдал хангана” гэсэн зорилтыг хэрэгжүүлэн ажиллажээ. Одоогоор нийт 30 ажилтан ажиллаж байна. Тус компани нь жилдээ 400-900 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Авто зам засвар, арчлалт, зам гүүрийн барилгын ажил гүйцэтгэх хүчин чадалтай компани юм. Говь-Алтай аймагт зам ашиглалтын анги үүссэн цагаас өнөөг хүртэл Авто зам гүүр барих, засварлах ажлыг найдвартай чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна.

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Аж ахуйн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Авто замын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Говь-Алтай АЗЗА ТӨХК санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Говь-Алтай АЗЗА ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Macs” програм хангамж ашигладаг байна.

Говь-Алтай АЗЗА ТӨХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Говь-Алтай АЗЗА ТӨХК бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээ Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын үзүүлэлтийг сонгов.

Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг компани нь төрийн өмчит компани, мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн бага дүнтэй тул сонгосон ба материаллаг байдлын түвшинг тогтоохдоо хэрэглэгчдийн хэрэгцээ, өмнөх жилийн аудитын тайлангаар гарсан алдаа, зөрчлийн дүн, агуулгыг бас харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал нь 568.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийн “Дунд” үнэлгээг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дуусаагүй үйлвэрлэлийн асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 614 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан байна.

Тус компани нь 2018 оны зорилтот түвшинд нийт орлогыг 613.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс улсын чанартай зам засвар арчлалтын үйл ажиллагаанаас 388.2 сая төгрөг, орон нутгийн чанартай замын тендер болон бусад үйл ажиллагаанаас 225.0 сая төгрөг бүрдүүлэхээр тооцсон. Гүйцэтгэлээр улсын чанартай зам засвар арчлалтын үйл ажиллагаанаас 409.8 сая төгрөг, орон нутгийн чанартай замын тендер болон бусад үйл ажиллагаанаас 160.4 сая төгрөгний орлого олж орлогын төлөвлөгөөг 43.0 сая төгрөгөөр буюу 7.0 хувиар дутуу биелүүлсэн байна.

Нийт зардалд 609.5 сая төгрөг, үүнээс зам засвар арчлалтын зардалд 462.9 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 146.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр зам засварын арчлалтын зардал 435.2 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 132.1 сая

төгрөг нийт зардалд 567.3 сая төгрөгийг зарцуулсан ба 2.1 сая төгрөгний цэвэр ашигтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Говь-Алтай АЗЗА ТӨХК нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг бүрэн оруулсан байна. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг, худалдан авалт, хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн

Говь-Алтай АЗЗА ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан**3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	241,048,471.79	184,970,705.92
1.1.2	Дансны авлага	8,065,875.00	3,065,875.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	1,385,511.00
1.1.4	Бусад авлага	615,337.00	765,337.00
1.1.6	Бараа материал	46,622,972.55	131,463,152.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,996,500.00	
	Эргэлтийн хөрөнгийн дүн	303,349,156.34	321,650,581.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	501,105,977.16	495,174,098.21
1.2.2	Биет бус хөрөнгө	1,060,000.00	351,880,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	502,165,977.16	847,054,098.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	805,515,133.50	1,168,704,680.05
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	583,575.00
2.1.1.3	Татварын өр	2,634,389.22	475,588.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,634,389.22	1,059,163.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	283,600,889.00	283,600,889.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	283,600,889.00	283,600,889.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	286,235,278.22	284,660,052.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	101,167,000.00	101,167,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,550,846.07	16,543,677.13
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	407,510,781.33	758,570,781.33
2.3.9	Хуримтлагдсан ашиг	6,051,227.88	7,763,169.59
2.3.11	Эздийн өмчийн дүн	519,279,855.28	884,044,628.05
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	805,515,133.50	1,168,704,680.05

3.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	570,860,701.57	555,649,900.27
2	Борлуулалтын өртөг	459,085,433.35	414,504,409.06
3	Нийт ашиг(алдагдал)	111,775,268.22	141,145,491.21
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	9,308,859.41	12,157,392.62
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		2,363,636.36
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	105,393,327.43	132,083,956.19
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	14,026,857.64	20,271,394.29
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,363,635.91	431,250.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,027,578.47	2,879,919.71
19	Орлогын татварын зардал	502,757.85	775,588.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,524,820.62	2,104,331.71
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,524,820.62	2,104,331.71
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

3.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	101,167,000.00	6,002,796.07	407,510,781.33	74,457.41	514,755,034.81
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				4,524,820.47	4,524,820.47
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-1,451,950.00		1,451,950.00	-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	101,167,000.00	4,550,846.07	407,510,781.33	6,051,227.88	519,279,855.28
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,104,331.71	2,104,331.71
13	Бусад дэлгэрэнгүй орлого					363,957,541.06
14	Өмчид гарсан өөрчлөлт		12,897,541.06	351,060,000.00		
15	Зарласан ногдол ашиг				-452,490.00	-452,490.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-904,710.00		60,100.00	-844,610.00
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	101,167,000.00	16,543,677.13	758,570,781.33	7,763,169.59	884,044,628.05

3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	629,851,499.00	624,705,489.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	618,042,847.00	613,459,748.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	11,808,652.00	11,245,741.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	567,182,496.73	665,884,457.49
1.2.1	Ажиллагчдад төлсөн	132,175,499.00	150,353,210.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,625,674.23	54,729,720.89
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	89,979,860.00	117,244,370.70
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,026,984.00	5,162,314.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	178,839,725.00	191,274,680.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	58,598,461.00	60,412,087.90
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,569,925.00	1,604,375.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	62,366,368.50	85,103,699.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	62,669,002.27	-41,178,968.49
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,008,859.41	12,157,392.62
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3,700,000.00	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	9,308,859.41	12,157,392.62
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,921,000.00	26,603,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,921,000.00	26,603,700.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,912,140.59	-14,446,307.38
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		-452,490.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг		452,490.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-452,490.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	56,756,861.68	-56,077,765.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	184,291,610.71	241,048,471.79
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	241,048,471.79	184,970,705.92

3.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант оны		Харьцуулалт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Дүнгээр
1	Нийт орлого	613,197.9	570,170.9	92.98%	-43,027.00
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	388,197.9	409,752.4	105.55%	21,554.5
	Бусад	225,000.0	160,418.5	71.30%	-64,581.50
2	Нийт зардал	609,518.8	567,290.9	93.07%	-42,227.90
	Удирдлагын зардалд	146,592.9	132,083.9	90.10%	-14,509.00
3	Татварын өмнөх ашиг	3,679.1	2,880.0	78.28%	-799.10
4	Цэвэр ашиг/ алдагдал/	3,311.2	2,104.3	63.55%	-1,206.90
5	Орлогын татварт	367.9	775.7	210.85%	407.8
6	Нийт ажиллагсдын тоо	30.0	30.0	100.00%	-
7	Цалингийн сан	210,801.1	193,928.4	92.00%	-16,872.70
8	Нийт авлага	20,412.30	5,216.70	25.56%	-15,195.60
9	Нийт өглөг	302,058.50	284,660.10	94.24%	-17,398.40
10	Үүнээс: Богино хугацаат	18,457.60	1,059.20	5.74%	-17,398.40
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.99	0.99	100.00%	-
12	Хөрөнгө оруулалт	27,050.00	26,603.70	98.35%	-446.30

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.